



**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
XI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар XI/10

Булган сум

Санал уламжлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн XI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу сумын Засаг даргаас ирүүлсэн 2023 онд шинээр газар өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг дэмжиж, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх саналыг 1 дүгээр, гэр бүлийн зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх саналыг 2 дугаар, өмчлүүлэх газрын байршлыг 3 дугаар хавсралтаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсугай.

2. Газар зохион байгуулалттай холбоотой асуудлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Б.ГАНЗОРИГ